

Дашинчилэн сумын Цэцэрлэгт төлөвлөгөөт бус  
хяналт шалгалт хийсэн тухай

**Хяналт шалгалтын зорилго**

Булган аймгийн засаг даргын баталсан Дашинчилэн сумын “Нарлаг” Цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг үндэслэн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 1/22 тоот удирдамжийн дагуу санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтыг хангуулах, цалин хөлс олгосон байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад оршино.

**Хяналт шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа**

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ц.Алтанхуяг  
2017 оны 11 дүгээр сарын 02-оос ажлын 1 хоног

**Шалгалтанд хамрагдсан байгууллага, объектын нэр**

Дашинчилэн сумын Нарлаг Цэцэрлэгийн 2016, 2017 оны санхүүгийн баримтаас цалин хөлс, хандив тусламжтай холбоотой баримт материалыг түүвэрлэн хамруулав.

**Шалгалтанд хамрагдсан асуудал**

Туслах багш Д.Шижиртогоо, Ц.Ариунбулаг нарт илүү цагийн хөлс олгосон байдал.  
Хандив тусламжаар ирсэн хөрөнгө мөнгө түүний зарцуулалт.  
Ур чадвар, үр дүнгийн урамшуулал олгосон байдал.

**Шалгалтанд хамрагдсан объектын талаарх  
товч мэдээлэл**

Булган аймгийн Дашинчилэн сумын 4-р багт байршилтай Нарлаг Цэцэрлэгийн 1-р гарын үсгийг 2016, 2017 онд эрхлэгч Н.Алимаа, 2-р гарын үсгийг нягтлан бодогч Р.Билгүүнмаа нар зурж төрийн санд бүртгэлийн 100040515201, нэмэлт санхүүжилтийн 100040515403 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

**Өмнөх шалгалтын талаар**

Булган аймгийн Аудитын газраас тус газрын 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэжээ.

**Шалгалтын явцад хийгдсэн ажил,  
шийдвэрлэсэн асуудал**

Тус цэцэрлэгийн 2016, 2017 оны касс, харилцахын баримт, няравын тайлан, эрхлэгчийн тушаал, цалин олгох хүснэгт, санхүүгийн тайлан, цалингийн карт, дансны хуулга зэрэг баримт материалуудад тулгуурлан Эрхлэгч Н.Алимаа, Нягтлан бодогч Р.Билгүүнмаа, Нярав Г.Солонго нарыг байлцуулан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ.

Шалгалтын явцад 2 туслах багшийн илүү цагийн олголтыг цалингийн цэс, цалингийн карт, цаг бүртгэлийн дэвтэр, цагийн тооцоо зэргийн тулган шалгав.

Хандив тусламжаар ирсэн хөрөнгө мөнгийг 2016, 2017 оны санхүүгийн тайлан, няравын тайлан, дансны хуулга зэрэг материалд тулгуурлан үзэв.

Ур чадвар, үр дүнгийн урамшуулал олголтыг цалингийн цэс, цалингийн карт, тушаал шийдвэр зэрэг материалд тулгуурлан шалгалаа.

### **Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан**

1. Туслах багш Д.Шижиртогоод илүү цаг 2016 онд 42 цаг буюу 154,728 төгрөг, Ц.Ариунбулагт илүү цаг 2017 онд 5 цаг буюу 19,770 төгрөг нийт 174,498 төгрөг илүү олгосон байгаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.6-д / Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 13.7-д /Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасан заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. 2016 оны 08 сарын 25 нд иргэн Ц.Төмөрбаатараас хандиваар Цэцэрлэгийн Хаан банк дахь 5276067339 тоот дансанд 500,000 төгрөг шилжүүлсэнг эрхлэгч Н.Алимаа нь 2016 оны 08 сарын 26 нд авч эд хогшил худалдан авсан гэх боловч няравын тайланд орлого аваагүй, санхүүгийн тайланд тусгаагүй, анхан шатны баримт огт байгүй байгаа нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 14.4-д /Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д аж ахуйн бүх ажил, гүйлгээ, 14.4.2-д бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, 14.4.5-д бүх орлого/ заасан заалтыг зөрчсөн байна.

3. Цэцэрлэгийн эрхлэгч Н.Алимаад 2016 онд сар бүр ур чадварын нэмэгдэл олгосон байна. 1-6-р саруудад аймгийн Засаг даргын 2016 оны 05 сарын 27-ны өдрийн А/257 тоот захирамжийн дагуу ур чадварын нэмэгдэл олгох ба 7-12-р саруудад үнэлэж дүгнэсэн эрх захирагчийн шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдлыг 7-р сард 60,102 төгрөг, 8-р сард 76,652 төгрөг, 10-р сард 230,793 төгрөг, 11-р сард 128,218 төгрөг, 12-р сард 128,218 төгрөг, нийт 623,983 төгрөг олгосон нь 2010 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 362/112/183 дугаар тушаалын хавсралтын 7-д /Багш ажилтны ур чадварыг хагас жил тутам үнэлнэ./ мөн 10- т /Ерөнхий боловсролын сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгчид ур чадварын нэмэгдэл олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг аймгийн Боловсрол, соёлын газар, дүүргийн Боловсролын хэлтсийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн захирал, эрхлэгчийг томилсон этгээдийн шийдвэрээр шийдвэрлэнэ./ заасныг тус тус зөрчсөн байна.

4. Эрхлэгчийн тушаалыг үдэж архивлаагүй байна.

### **. Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал**

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар улсын байцаагчийн 3 актаар 1,298,481 төгрөгний төлбөр тогтоов. Зөрчил дутагдлыг арилгуулж, таслан зогсоох зорилгоор 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

### **Дүгнэлт**

Тус байгууллагад Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, 14.4 дахь заалтууд, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар” зэрэг хууль тогтоомжууд хангалтгүй хэрэгжиж байна.

Хандив тусламжаар ирсэн хөрөнгө мөнгийг бүртгэл тайланд тусгадаггүй, юунд зарцуулсан нь тодорхой бус, анхан шатны баримтуудыг үндэслэж бүртгэл тайланг хөтлөөгүй байгаа зэрэг нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт хийгдээгүй, эрхлэгч, нягтлан бодогч нарын ажлын хариуцлага сул байгааг харуулж байна.

#### **Цаашид авах арга хэмжээний санал**

1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, улсын байцаагчийн актаар тогтоогдсон төлбөрийг хугацаанд нь барагдуулж, мэргэжил арга зүйн зөвөлгөөг биелүүлж ажиллах

2. Дотоодын хяналт шалгалтыг сайжруулж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

БИЧСЭН:

САНХҮҮ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ц.АЛТАНХУЯГ